



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/79

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Газар зохион байгуулалт хийх журам"-ын 8.3, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны А/40 дүгээр тушаалын хавсралт "Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар"-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар, Шаамар сумдын хилийн цэсийн тодруулалтын ажлыг зохион байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна буюу өөр сумын нутаг дэвсгэрт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг хүчингүй болгож, зөрчилтэй нэгж талбаруудын холбогдох захирамж, шийдвэрийг шинэчлэн гаргах, иргэн, хуулийн этгээдийн газрын эрхийг баталгаажуулах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Сайнцог	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга Б.Саруултөгс	-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд Д.Ёндонжамц	-Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
Т.Гантулга	-Сүхбаатар сумын Засаг дарга
М.Баярбаатар	-Шаамар сумын Засаг дарга
Б.Отгонзаяа	-Сүхбаатар сумын Засаг даргын орлогч
Ж.Доржхуяг	-Шаамар сумын 1 дүгээр багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга
Ц.Отгонбаяр	-Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын ахлах Бүртгэгч

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801760

Д.Бадам-Осор

-Шаамар сумын Улсын бүртгэгч

Э.Болор-эрдэнэ


-Сүхбаатар сумын Газрын даамал

Э.Жаргалбадрах

-Шаамар сумын Газрын даамал

2. Сумын хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (Ж.Сайнцог)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ